

## ЗУРААЧ С.МӨНГӨНЗУЛЫН "ГҮНЖ" ҮЗЭСГЭЛЭН, ЗОХИОЛЧ Б.ШҮҮДЭРЦЭЦЭГИЙН "ЭРВЭЭХЭЙН СҮНС" НОМЫН ӨДӨРЛӨГИЙН ТАЙЛАН

2023.03.24

Дархан-Уул аймаг

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар болон Эмэгтэйчүүдийн холбоо, Дарханы Зураач урчуудын эвлэл хамтран 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зураач С.Мөнгөнзулын анхны бие даасан уран бүтээлийн "ГҮНЖ" үзэсгэлэн, мөн зохиолч Б.Шүүдэрцэцэгийн "Эрвээхэйн сүнс" номын өдөрлөгийг хамтатган аймгийн Эмэгтэйчүүдийн ордонд зохион байгууллаа.

Үзэсгэлэнг Соёл, урлагийн газрын дарга Х.Соёл-Эрдэнэ нээж тус өдөр зураач С.Мөнгөнзул Монгол Улсын Засгийн газрын шагнал "Соёлын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр энгэрээ мялаалаа. Үзэсгэлэн нь түүний бие даасан анхны үзэсгэлэн бөгөөд 30 орчим уран бүтээл дэлгэгдэж 10 хоног толилуулсан.



Соёл, урлагийн газраас С.Мөнгөнзул зураачид бүх нийтэд боловсрол олгох, соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмэр оруулсанд Талархал гардууллаа.

Тус өдөр Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Б.Шүүдэрцэцэгийн "Эрвээхэйн сүнс" өгүүллэгийн номын нээлтийг хоёр удаа зохион байгууллаа. Зохиолч, уншигчийн уулзалтын эхэнд зохиолч Б.Шүүдэрцэцэг нь 11 уран зураг, 11 өгүүллэгээс бүтсэн цоморлиг номоо Мартын 8-ны босгон дээр уншигчдадаа, тэр дундаа Дархан хотынхондоо хамгийн түрүүнд хүргэж буйдаа баяртай байгаагаа илэрхийллээ. Мөн тэрээр зохиолчийн гараагаа эхлүүлснээс хойш эдүгээ 20 дахь жилтэйгээ золгож буй талаар, түүхэн романуудаа хэрхэн бичиж эхлүүлсэн, яагаад Монголын түүхэн хатдын сэдвээр бичих болсон тухай, NFT арт худалдаанд орсон анхны зохиолч болсон зэрэг олон сонирхолтой түүхээр халуун дотно яриа өрнүүлсэн юм.

"Эрвээхэйн сүнс" өгүүллэгийн цоморлигод Дархан-Уул аймгийн зураач, Соёлын Тэргүүний ажилтан С.Мөнгөнзулын "Сангиражи гүнж" уран зураг багтсан бөгөөд тус бүтээлээр өгүүллэг зохиогдсоноороо онцлог юм.



Мөн "ГҮНЖ БА ЭРВЭЭХЭЙН СҮНС" өдөрлөгийн үеэр MSM Royal Liquor shop-оос WINE & ART" дарсны соёл, дарс ба хоолны зохилдлого зэрэг сонирхолтой мэдээлэл өгч амталгаат худалдааг зохион байгууллаа.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР